

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Сандуйдагва	Дугаар	L218
Оршин суугаа аймаг	Архангай	Оршин суугаа сум	Өгийнуур сумын Орхон баг
Төрсөн газар	Өгийнуур сум	Төрсөн он	1940
Ажил мэргэжил	Өндөр настан, Хорчин хийдийн гэсгүй		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Хорчингийн хурал	Сүм хийдийн дугаар	АРДЧ 069
Одоогийн сүм хийд	Хорчингийн хурлын шинээр сэргээгдсэн хийд	Сүм хийдийн дугаар	АРДЧ 016
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 7-р сарын 22	Ярилцлага авсан хүн	Д.Мөнхбат



Архангай аймгийн Өгийнуур сумын Хорчингийн хурал

Сануйдагва гуй бол Хорчингийн хурлын түүриас холгүй 10 орчим км газарт шинэ цагийн Хорчингийн хурлыг сэргээж яваа буянтай буурал юмаа. Тэгэхээр таны ярианаас үзвэл Хорчингийн хурал бараг 300-аад жилийн түүхтэй 17-р зууны сүүлч 18-р зууны эхэн үеэр байгуулагдсан түүхтэй юмаа. Одоо энэ Сайнноён хан аймгийн ууган хүрээ хийдүүд болон Түшээт хан аймаг мөн монголын буддын шашны анхны сүм хийд болох Өвөрхангайн Эрдэнэзуу хийд эд нартай бараг мөр зэрэгцэн арай ч төгсгөлд нь байгуулагдсан гэж үзэж байна уу та ?

Сануйдагва: Үгүйээ тийм би Зуутайгаа л цуг яваад байгаа гэж үздэг. Зуутайгаа л чацуу шахуу.

Д. Мөнхбат: Тэгэхээр та лав 300-аад жилийн өмнө байгуулагдсан гэж үзэж байна уу?

Сануйдагва: Тийм л гэж үзэж байна.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Д. Мөнхбат: Хичнээн лам хуврага хэдэн тооны дуган байсийм бол , 4-5 туурь л байгаа бололтой ?

Сануйдагва: 200 жаахан илүү ламтай байсан 4-5 дугантай байж .

Д. Мөнхбат: Жас хөрөнгийн санхүүгийн хувьд ямархуу чадалтай байсан юм бол ?

Сануйдагва: Жас хөрөнгөний хувьд их баян хөрөнгө сайтай байсийм гэнэ лээ хонь гэхэд л түм хүрч ган тулга олгогдож байсан гэдэг.

Д: Мөнхбат: Гантулга гэж юуг хэлж байсан бэ?

Сануйдагва: Одоо яахав энэ хөдөлмөрийн баатар сайчуудад өгдөг шиг л тийм шагналын зүйл юмуу даа.

Д.Мөнхбат: Хичнээн жастай байсан юм бэ?

Сануйдагва: Гурван жастай байсан.

Д.Мөнхбат: Хорчингийн хурлын гол шүтээн сахиус нь юу байсан юм бол ?

Сануйдагва: Махгал.

Д. Мөнхбат: Энэ Махгал бурхан сахиус чинь одоо шашны ямар утга санаа бэлгэ дэмбэрлийг агуулж илэрхийлдэг бурхан бэ?

Сануйдагва: Сайн мэдэхгүй юм 75 Махгал л гэдэг шүү дээ.

Д.Мөнхбат: Энэ хурлын үүсгэн байгуулагч нь хэн гэдэг хүн гэлээ та түрүүн ярьж байсан ?

Сануйдагва: Дамдинжав гэлэн гэдэг хүн.

Д.Мөнхбат: Энэ хүн аль нутгийн хүн бэ?

Сануйдагва: Энэ Хашаатын хүн энэ Хашаатын урьд талын хүн байсан гэнэ лээ.

Д.Мөнхбат: Таныг хүүхэд ахуй үед нутаг орны хөгшчүүлийн ярьж байсан яриа хуучинд энэ хуралд ямар ямар эрдэм чадалтай лам нар байсан тухай сонсож мэдсэн зүйл байна уу танд ?

Сануйдагва: Үгүй ээ гэлэнгээс л дээш гавьж аграмба цол хэргэм мяндагтай лам нар л байсан гэдэг

Д.Мөнхбат: Байнгын хуралтай байсан уу ?

Сануйдагва: Байнгын хуралтай цагаан сарын хурал гэхэд л өмнөх 25-наас шинийн 15 хүртэл байнга хурдаг, нямба хийж байгаад тэгээд хонио хургалуулна гээд хөдөөлдөг байсан гэдэг. Зуны эхэн сарын шинийн 1-нээс 8-р сараа дуустал хурна. Тэгээд дараагийн хурлаа хийнэ.

Д.Мөнхбат: Бас нэг ийм юм байгаа юмаа. Монголын хүрээ хийдүүд ингээд судлаад асуугаад явж байхад өөр өөрийн гэсэн онцлогтой байжээ . Жишээ нь: Архангай аймгийн Чулуут сумын нутагт байсан Шивааширээтийн хүрээ гэхэд л их онцлог цамтай тэндхийн цамд гэхэд эрвээхэй бүжиг гэж гарч байжээ үүгээрээ их онцлог. Үүнтэй адилхан Хорчингийн хурал бусад хүрээ хийд хурал номын газраас ялгагдах онцлог юм юу байна таны бодож байгаагаар ?

Сануйдагва: Үгүй энэ чинь Зуугийн хувилгаан Гончигжанцанжалцан гэж том хувилгаан хүн байсан. Түшээт ханы 3 хувилгааны нэг, түүнийг жил тутам залж ирүүлнэ. Нүннээ их сахиулна үе үе нүннээ сахина. Тийм л газар байсийм гэнэ лээ.

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Д.Мөнхбат: Хорчингийн хурал хажуудаа зарим томоохон сүм хийд шиг шашин номын сургалт явуулдаг дацан байхгүй байсан байх тийм үү?

Сануйдагва: Хоёр жижиг цогчин дугантай байсан гэдэг түүнийхээ нэгэнд нь цогчин хурлаа хийдэг нөгөөд нь багачууд ном зааж сургадаг байсан юм гэнэ лээ. Лам нараа дороос нь зааж сургаж бэлтгэдэг байж.

Д. Мөнхбат: Тэгэхээр энэ хуралд ямар ямар томоохон хурал хүрж байсан юм бэ ? хаварт , өвөлдөө, намартаа ч гэдэг юм уу?

Сануйдагва: Сахиусаа хурдаг буман сан их хурдаг байсийм гэнэ лээ бусдыг нь би нас гүйцэж сайн мэдэхгүй байна.

Д.Мөнхбат: За одоо төгсгөлийн үе рүү нь оръё хурал номын газрынхаа. 1937, 1938 онд монгол орон даяар буддын шашны сүм хийдийг устгаж байсан тэр цөвүүн цагт Хорчингийн хурлын хувь заяа ямар байсан юм бол , та түрүүн хэлж байсан 1938 онд бүрэн хаагдсан гэж лам нарыг нь баривчлаад сүм дуганыг шууд шатааж устгасан юм болов уу эсвэл лам нарыг нь тарааж баривчилчихаад сүм дуган нь эзгүйрчихээд байсан юм болов уу ?

Сануйдагва: Шууд нураагаад хаясан юм. Тэгээд хөдөө газар яахав дээ үхэр тэргээр зарим хүн зөөгөөд л түлж ч байсан түлсэн хүн амжилт олохгүй шүү сүйд болно шүү гээд л хэлж захиж байсан. Лам нарыг нь шууд бариад л ингээд л уруудуулаад л бөөн бөөнөөр нь 50 , 100 гаар нь мориор туугаад л тэр хөгшин амьтдыг одоо бидний аав ээж орилж хашгираад л голгүй улс шүү. Тэгээд л хуучин Лүнгийн төвд аваачиж бөөн бөөнөөр нь машинд чихээд л Архангайд аваачиж алсан юм гэдэг. Сүсэгтний анхдугаар хурал дээр /аймгийн / тэр доод руу нь алсан газар нь гээд л хүмүүс үйлж зарим нь ухаан алдаж унаж сүрхий юм болж байсан .

Д.Мөнхбат: Хорчингийн хурлын төгсгөлийн цаг үед танай аав ээж төрөл төрөгсдөөс шавилж байсан , хуралд хүрж байсан ийм хүмүүс байсан үү?

Сануйдагва: Байсан байсан олон байсан.

Д.Мөнхбат: Жишээлбэл ?

Сануйдагва: Манай аав Содномдаржаа гэвш гэж хүн байлаа, ээжийн эцэг Лувсандорж гэлэн гэж их том хүн байсан, Амаа гавьж гэж их мундаг хүн одоо энэний хамба нь байсан гэдэг. Жигтэйхэн их шуурга шуураад хонио алдчихсан Амаа гавьж унтаж байж. Тэгээд хөөе Амаа яасан хонио алдчихлаа гэсэн чинь шуурга эргээд хонь нь гадна нь хүрээд ирсэн гээд л сонин сонин юм их л ярьдаг байсан их эрдэм чадалтай хүмүүс олон байсан юм гэнэ лээ.

Д.Мөнхбат: За таньд баярлалаа. 300-аад жилийн түүхтэй Хорчингийн хурлын тухай таны хэлж ярьж өгсөн энэ үнэтэй мэдээлэл монголын сүм хийдийн түүхэн товчоо төслийн багийн судалгааны ажилд үнэтэй хувь нэмэр оруулна гэхэд итгэж байнаа.

Архангай аймгийн Өгийнуур сумын Шинэ Хорчингийн хурал

Д. Мөнхбат: За өнөдөр 7-р сарын 22-ны өдөр. Манай баг Өгийнуур сумын Орхон багийн нутаг Улаанхудаг гэдэг газраас судалгааны ажлаа үргэлжлүүлж байнаа. За энэ газар нутаг бол монголын төрт ёсны болон буддын

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

шашны түүхэнд холбогдох онцлог газар. Энд Ренчин авхайн бүртгэлд Хорчин гүний хүрээ нэрээр нэрлэгдсэн хурал номын газрыг 1994 онд сэргээн байгуулсан тул бид шинэ сүм хийдийн бүртгэлийн дагуу ярилцлага хийж байна . Юуны өмнө Хорчингийн хүрээ байсан одоогийн шинэ цагийн Хорчингийн хүрээ сэргээгдсэн энэ газар нутаг бол одоогоос 400 шахам жилийн тэртээ монголын төр ёсны нийслэл болох Өндөр Гэгээний шар бүсийн өргөө 1640- 1654 онд энд , 1639 онд анх Өвөрхангай аймгийн Ширээцагаан нүүрт байгуулагдсаныхаа дараа 2 дахь удаагаа нүүдэллэн энд суурьшиж байжээ. Үүнийг ч шинжлэх ухааны судлаачид манай түүхч археологичид хамтран судалж тогтоогоод одоогоос 4 жилийн өмнө буюу 2003 оны 10 сарын 29- ны өдөр нийслэлийн ИТХТ, нийслэлийн ЗДТГ хамтран одоо энэ Хорчингийн шинэ цогчин дуганы чанх хойно арваад метр орчимд 1640-1654 оны хооронд монгол улсын нийслэл энд оршиж байжээ гэсэн бичээс бүхий дурсгалын хөшөөг босгожээ. За ийм төр шашны уламжлалтай ариун дагшин газар байх юмаа энэ орон нутаг. Тэгэхээр бид 300-аад жилийн түүхтэй Хорчингийн хурлыг шинээр сэргээн үүсгэн байгуулсан Сануйдагва гуайтай дараах ярилцлагыг хийсэн юмаа. За таниас хэд хэдэн зүйлийг асууя.

- Та энэ Хорчингийн хурлыг шинээр сэргээн үүсгэх ямар ямар бодит нөхцөл шалтгаан байгаа ?

Сануйдагва: Аав ээжийнхээ уламжлалаас сэргээе гэж үнэн голоосоо зүтгэсэн гол сүмийнхээ уламжлалыг сэргээе гэсэн юм аа том хийдээ бол чадахгүй л дээ .

Д.Мөнхбат: Тэгэхээр энд нэг зүйлийг тэмдэглэхэд Сануйдагва гуайн аав бол Хорчингийн хүрээнд сүж байсан Содномдаржаа гэвш гэж хүн байсан энд шинэ Хорчингийн хурлыг үүсгэн байгуулагч гэсэн 3 хүний нэг нь Ёндонжамц гэж нэр байна. Энэ хүн бол Сануйдагва гуайн төрсөн хүү. 2003 онд шашны их сургууль төгсөөд одоо Гэсэр сүмийн Ёга дацанд суудаг. Тэгэхээр үндсэндээ гурван үеэрээ дамжин Хорчингийн хийдийн зул хүж бурхан тахилыг таслахгүй байх л хувьтай хүмүүс байж дээ. Та энэ цогчин дуганыг босгох гэж одооны ярьдгаар бор зүрхээрээ л зүтгэсэн гэсэн ямар ямар саад бэрхшээл байв, сүсэгтэн олон , сүм орон нутаг дээрээс аймгаас ямар дэм туслалцаа авав ?

Сануйдагва: Өөрийн тэтгэврийн хэдээрээ л эхэлж зүтгэсэн яахав багийн 50, 60 хонь цугласан төлөг голдуу түүнийг нь зарж борлуулж мөнгө болгосон сүсэгтэн олноос цугласан тав арван төгрөг байсан ингээд л зүтгэж өдий хүргэсэн.

Д.Мөнхбат: Одоо 4 ламтай, цагийн хуралтай гэж байгаа тиймээ?

Сануйдагва: Тиймээ цагийн хуралтай . Шинийн 8 , 15, 29-нд хурна

Д.Мөнхбат: Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн 1 – 15 хүртэл хурдаг гэсэн үү ?

Сануйдагва: Тиймээ тэр үеэр хурна.

Д.Мөнхбат: Та байнгын хуралтай болгох , тогтмол суух ламтай байх талаар ямар бодол санаатай байнаа?

Сануйдагва: Тэр их хэцүү уг нь ном ёсны лам нар байна. Гэтэл хөдөө газарт таван цаас ч аваад өгч чадахгүй тэгэхээр лам нар ирэхгүй хэрэгтэй газар луугаа яваад өгнө.

Д.Мөнхбат: За энэ шинэ цагийн Хорчингийн хийд хөдөө орон нутаг бусад сумдад байдаг зарим хийд хурал номын газруудаас ялгагдах онцлог байна. Байнгын эзэнтэй учраас бурхан тахил, ном судар, шашны эд өлгийн

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

бусад зүйлс ном ёсоороо байна нэгдүгээрт, за хоёрдугаарт сумын төв сүсэгтэн олны хөлөөс зайдуу хуучин Хорчингийн хүрээний тууриа бараадаж байгуулагдсан ч Хархориноос Өгийнуур явдаг төв замын дэргэд байдаг учир аянчин гийчин жуулчдын хөл тасрахгүй байгаа нь биднийг энд байх хэдхэн цагийн дотор ажиглагдаж байна. Хэдийгээр том биш 10-12 метр радиустай модон гэр дуган ч хөөрхөн тохижсон , материаллаг баазын хувьд бэхэжсэн айгаа нь анхны сэтгэгдлээр төрж байна. 1996 онд үндсэн шүтээн болох Махгал бурханаа бүтээлгэсэн бөгөөд 1992 онд анх ердийн монгол гэрт хурлаа эхэлж байсан бол 1995 онд энэ модон дуганыг өөрсдийн хүч хөрөнгө сэтгэл зүрхээр босгожээ. 2006 онд Сануйдагва гуайн хүү Ёндонжамц Гүмбэнгээс Ганжуур залж ирсэн бол 2003-2005 онд тус бүр нэг нийлээд 2 бодь суваргыг бүтээж дуганыхаа хоёр талд босгожээ. За ингээд Сануйдагва гуай таньд эцэг өвөг дээдсийнхээ бурхан тахил , зул хүж, хонх дамрын дууг таслахгүй буянын цагаан мөр чинь өлзийтэй байх болтугай гэж ерөөеөө. Та урт наслаарай.